



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: statgreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2022.03.14 № 07

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2-т "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашиг, өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-иас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэнэ" гэж, мөн тус хөтөлбөрийн 2.1.3.1-2.1.3.7-д зааснаар Эртхэн шилжүүлэн суулгах үндэсний төв, Зүрх судасны үндэсний төв, Сүрьеэгийн эмнэлэг, Геронтологийн үндэсний төв, Түлэнхийн төв, Халвдарт өвчин судлалын үндэсний төвийн салбар-II, Хавдар судлалын үндэсний төвийн салбар эмнэлэг-II зэргийг тус тус шинээр байгуулахаар тусгасан.


Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-иас дээш хувийг эмчилгээнд хамруулах ажлын явцын талаар;
2. Хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэж, улсын хэмжээнд хэрхэн зохион байгуулах талаар;
3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний төвүүдийг бүтээн байгуулах ажлын явцын талаар тодорхой мэдээллийг хуульд заасан хугацаанд ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлж, цаашид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.ЧИНБҮРЭН

2022000011